

**АВЛИГАТАЙ ТЭМЦЭХ ГАЗАР, АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН 2022 ОНЫ 12 ДУГААР САРЫН 09-НИЙ ӨДРИЙН  
АЛБАН БИЧГЭЭР ХҮРГҮҮЛСЭН ЗӨВЛӨМЖИЙН БИЕЛЭЛТ**

Бат-Өлзий сум

2023.12.08

Д/Д	ЗӨВЛӨМЖ	БИЕЛЭЛТ
1	Мэдүүлгийг бүртгэх, хадгалах эрх бүхий албан тушаалтныг мэргэшүүлж, тогтвор суурьшилтай ажиллуулахад анхаарч, тэднээс эрх, үүргээ хэрэгжүүлэхэд байгууллагын удирдлагын зүгээс дэмжлэг үзүүлэх, шаардлагатай мэдээллээр хангаж ажиллах.	Авлигын эсрэг хууль, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль тогтоомж, Авлигатай тэмцэх газрын даргын 2018 оны А/121 дүгээр тушаалаар батлагдсан “Албан тушаалтны хувийн ашиг сонирхлын мэдүүлэг болон хөрөнгө, орлогын мэдүүлгийг бүртгэх, хянах, хадгалах, эрх бүхий албан тушаалтны үйл ажиллагааны журам”-ын төрийн байгууллагын удирдлагатай холбоотой зүйл заалтыг өдөр тутмын үйл ажиллагаандаа хэрэгжүүлж ажилласан.
2	Нийтийн албан тушаалтан албан үүргээ гүйцэтгэх явцад ашиг сонирхлын зөрчил үүссэн, үүсэж болзошгүй нөхцөлд албан үүргээ гүйцэтгэхээс татгалзаж бичгээр мэдэгдэх, ашиг сонирхлын зөрчилтэй гэж ойлгогдохуйц нөхцөл байдал үүсвэл бичгээр тайлбар гаргаж хэвшүүлэх талаар зохион байгуулалтын арга хэмжээ авах.	Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 8 дугаар зүйлд “Ашиг сонирхлын зөрчлийг мэдэгдэх, тайлбарлах” тухай заалтыг хэрэгжүүлж, мөн хяналт шалгалтаар нийтлэг илэрсэн зөрчил буюу уг хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.11-д "Ашиг сонирхлын зөрчилтэй гэж ойлгогдохуйц нөхцөл байдал" нийтийн албан тушаалтан албан үүргээ гүйцэтгэх явцад ашиг сонирхлын зөрчилтэй гэж ойлгогдохуйц нөхцөл байдал үүсгэхгүй байх талаар зохион байгуулалтын арга хэмжээг авч, тухай бүр мэдээллээр хангаж ажиллаа.
3	Нийтийн албан тушаалд томилогдсоноос хойш хуульд заасан хугацаанд Хувийн ашиг сонирхол, хөрөнгө орлогын мэдүүлэг /ХАСХОМ/ гаргаж хэвшүүлэх, хугацаандаа гаргаагүй албан тушаалтанд хариуцлага тооцож байх, түүнд тавих хяналтыг сайжруулах	Авлигын эсрэг хууль, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуульд заасны дагуу холбогдох албан хаагчдаар жил бүрийн 2 дугаар сарын 15-ны дотор хувийн ашиг сонирхлын хөрөнгө орлогын мэдүүлгээ шинэчлэн гаргаж хэвшсэн. ХАСХОМ-ыг хугацаа хоцроосон мэдүүлэг гаргаагүй.
4	Нийтийн албанд томилогдохоор нэр дэвшсэн этгээдийн хувийн ашиг сонирхлын урьдчилсан мэдүүлгийг хянуулахгүй	2023 онд Соёлын төвийн дарга, Эрүүл мэндийн төвийн дарга, Ерөнхий боловсролын шинэ сургуулийн захирал, СӨББ-3 дугаар цэцэрлэгийн эрхлэгч нарын ашиг сонирхлын урьдчилсан мэдүүлгийг хууль журмын дагуу Авлигатай тэмцэх газар явуулж дүгнэлтийн үндэслэн томилгоожуулсан.



	томилдог, томилсны дараа хянуулдаг зөрчлийг таслан зогсоох.	
5	Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 17 дугаар зүйлд заасан хандив авахтай холбоотой хязгаарлалтыг чанд мөрдөж, зөрчлөөс урьдчилан сэргийлэх, хууль зөрчин хандив авч буй үйлдлийг нэг мөр таслан зогсоох, хандивлагчтай холбоотой шийдвэр гаргахгүй байх.	Нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 17 дугаар зүйлд заасан Албан тушаалтан, төрийн болон нутгийн захиргааны байгууллага, нутгийн өөрөө удирдах байгууллага нийтийн хэрэгцээнд зориулан иргэн, хуулийн этгээдээс бэлэг, бусад санхүүгийн туслалцааг авах, хүсэхийг хориглоно гэсэн заалтыг чанд мөрдөж ажиллаж байна. Урьдчилан сэргийлэх зорилгоор БИНХурлуудаар 300 иргэнд Нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль тогтоомж, журмын талаар мэдээлэл өгсөн.
6	Худалдан авах чиглэлээр мэргэшсэн ажилтан, иргэн, хувийн хэвшил, төрийн бус байгууллагын төлөөллийг олон давтамжтай хамруулахгүй байх, ашиг сонирхлын зөрчил гарахаас урьдчилан сэргийлэх.	Худалдан авах ажиллагааны мэргэшсэн ажилтан бэлтгэх сургалтад 12 төрийн албан хаагчийг хамруулсан, иргэн, хувийн хэвшил, төрийн бус байгууллагын төлөөллийг тус мэргэшсэн ажилтан бэлтгэх сургалтад хамруулаагүй. Цахим тендерийн үнэлгээний хороонд ажиллаж байгаа үнэлгээний хорооны гишүүдэд ашиг сонирхлын мэдүүлгийг журмын дагуу бөглүүлж ажиллаж байна.
7	Тендерт оролцогчдын эрхийг зөрчих, бусдад давуу байдал үүсгэх, тендерийг нэр төдий зохион байгуулж байгаад дүгнэлт хийх, хууль тогтоомжийг нэг мөр хэрэгжүүлэх.	Цахим тендерт оролцогчдын эрхийг зөрчсөн, бусдад давуу байдал үүссэн асуудал гараагүй, ТБОНӨХБАҮХудалдан авах тухай хууль, хуулийн шинэчлэлийн Сангийн яам, Төрийн худалдан авах ажиллагааны газраас зохион байгуулсан сургалтад албан хаагчдыг хамруулж, хууль тогтоомжийг хэрэгжүүлэн ажиллаж байна.
8	Засаг даргын нөөц хөрөнгийг үрэлгэн, зориулалт бусаар зарцуулж байгаад дүгнэлт хийж, төсвийн сахилга батыг чангатгах, ялангуяа баяр ёслол, тэмцээн, уралдаан, наадам, шагнал, урамшуулал, дайллага, хүндэтгэл үзүүлэх, хайрхан тайх, буцалтгүй тусламж олгох зэрэг арга хэмжээнд уг хөрөнгийг зарцуулахгүй байх.	Засаг даргын нөөц хөрөнгийг Сангийн сайдын 2012 оны 11 дүгээр сарын 15 -ны өдрийн 239 дүгээр тушаалын хавсралтаар батлагдсан “Засаг Даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам”-ын дагуу зарцуулж байна. 2023 оны төсвийн жилд 25,0 сая төгрөг батлагдсан. Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх арга хэмжээ, цэргийн тоо бүртгэл, гамшгаас хамгаалах, өвс тэжээл татах, малын сэг зэм устгах, гамшгаас хамгаалах иж бүрэн сургалтын арга хэмжээний зардал зэрэг зардлуудад зарцуулсан.
9	Орон нутагт төрийн алба, төрийн жинхэнэ албан хаагчийг улс	Төрийн алба, улс төрийн жинхэнэ албан хаагчийг улс төрийн намын нөлөөллөөс ангид, хараат бусаар ажиллах нөхцөлийг бүрдүүлж Төрийн албаны тухай хууль болон бусад хууль,



	<p>төрийн намын нөлөөллөөс ангид, хараат бусаар ажиллах нөхцөл бүрдүүлэх, Төрийн албаны тухай хууль болон бусад хууль, тогтоомжоор хориглосон хориглолт, хязгаарлалтыг зөрчихгүй байх.</p>	<p>тогтоомжийн хориглосон хязгаарлалтыг хэрэгжүүлэн ажиллах талаар сургалт хийсэн. Албан хаагчдаар намын харьяаллаас ангид, хараат бус байх баталгаа гаргуулсан.</p>
10	<p>Төсвийн хэтрэлт, хэмнэлт, үр ашигтай байдлыг нарийвчлан тооцож, шаардлагагүй зардлыг тэвчих, "Төрийн хэмнэлтийн тухай хууль"-ийн хэрэгжилтийг төрийн бүх шатны байгууллага, нэгжийн түвшинд хангуулан ажиллахад анхаарах, түүнд тавих хяналтыг сайжруулах.</p>	<p>"Төрийн хэмнэлтийн тухай хууль"-ийн хэрэгжилт, тус хуулийг хэрэгжүүлэх Засгийн газрын 203 дугаар "Төрийн хэмнэлтийн тухай хуулийг хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай" тогтоол зэргийг бүх шатны байгууллага удирдлага, нягтлан бодогч, нарт хүргэж, хэрэгжилтийг хангахад анхааран, тогтмол хяналт тавин ажиллаж байна,</p>

БИЕЛЭЛТ ГАРГАСАН

ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН ДАРГА



Н.БАТ-ЭРДЭНЭ